



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 4/673

Мөрөн сум

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг
томилж, баталгаажуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.10, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.10.4, 15.3, 15.5, 15.30 дахь заалт, Авлигатай тэмцэх газрын 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 05/20157 дугаартай албан бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Олон нийтийн төлөөллийн сонгон шалгаруулалтаар тэнцсэн Лодойсамбуугийн Дамдинсүрэн, Жадамбын Лхагвасүрэн, хамт олны саналаар Нэгдсэн эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлийн эмнэлгийн төлөөллөөр сонгогдсон Төрмөнхийн Цэрэнсүрэн, Өлзий-Хутагийн Уранчимэг нарыг томилж баталгаажуулсугай.

2.Авлигын эсрэг хуульд заасны дагуу тус албан тушаалд томилогдсоноос хойш ажлын 30 хоногийн дотор хөрөнгө орлогын мэдүүлгээ гаргаж, төрийн албан хаагчийн хувийн хэргийг бүрдүүлэх, холбогдох хууль тогтоомжийг баримтлан ажиллахыг томилогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

3.Шинээр томилогдсон аймгийн Нэгдсэн эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд баталгаажуулсан захирамжийг холбогдох хууль тогтоомжийн дагуу гардуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Цэцэгмаа)-д даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Гандэлгэр)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР

Захирамж2024

6712012025